



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,  
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Үзэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр  
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,  
<http://www.mmhi.gov.mn>

2022.01.10 № 03/65

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗАРТ**

Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албанд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2021 оны жилийн эцсийн тайлан, мэдээг хүргүүлж байна.


Хавсралт 4. хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧИГ ИЙН  
ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ



00 08 0046

2022 оны 01... дүгээр сарын 10-ны өдрийн  
03/65 дугаар албан бичгийн 1/-р хавсралт



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ БОЛОН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГА,  
АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАН ГАРГАСАН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН  
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албанд хандаж 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 585 өргөдөл, гомдол, санал, хүсэлт иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн байна.

- |                                      |     |
|--------------------------------------|-----|
| - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд | 197 |
| - Ашигт малтмал, газрын тосны газарт | 362 |
| - Үндэсний геологийн албанд          | 26  |
| -                                    |     |

Дээрх өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн тухайд:

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж салбарын хэмжээнд ирсэн 585 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн 570 буюу 97.69 хувийг шийдвэрлэж, 15 буюу 2.31 хувийг хянан шийдвэрлэхээр ажиллаж байна. Үүнээс:


Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд нийт 197 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирснээс 185 буюу 93.9 хувийг хугацаанд нь шийдвэрлэж хариу хүргүүлсэн болно. Нийт өргөдлийн ихэнх хувийг хүний нөөц, салбарын шагнал, гавьяат цолны нэмэгдэл авах хүсэлт болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал эзэлж байна.

Ашигт малтмал, газрын тосны газарт хандаж ирүүлсэн нийт 362 гомдол, хүсэлтээс 359 буюу 99.17% хувийг хугацаанд нь шийдвэрлэж хариу хүргүүлсэн байна. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал нийт гомдол, хүсэлтийн 40 хувь, хүний нөөцтэй холбоотой асуудал 29 хувь, бусад асуудал 5.24 хувийг тус тус эзэлж байна.

Үндэсний геологийн албанд нийт 26 хүсэлт ирснээс бүгд хүний нөөцтэй холбоотой асуудал бөгөөд 100 хувь шийдвэрлэн ажилласан байна.

---oOo---

2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн  
03/65 дугаар албан бичгийн 2-р хавсралт




УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ,  
ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГА АШИГТ МАЛТМАЛ,  
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР БОЛОН ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНД  
ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН  
ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН  
/2021 оны жилийн эцсийн байдлаар/

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт	Бичгээр	Шийдвэрлэлт			Шийдвэрлэлт /хувиар/
				Шийдвэрлэж хариу өгсөн	Хугацаа хэтэрсэн	Хяналтад байгаа	
1.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	197	197	185	3	9	93.91%
2.	Ашигт малтмал, газрын тосны газар	362	362	359	-	3	99.16%
3.	Үндэсний геологийн алба	26	26	26	-	-	100%
<b>НИЙТ</b>		<b>585</b>	<b>585</b>	<b>570</b>	<b>3</b>	<b>12</b>	<b>97.69%</b>

Хүснэгт 1: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албанд 2021 онд ирсэн нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

2022 оны 01 дүгээр сарын 10 -ны өдрийн  
03/6.5 дугаар албан бичгийн 3-р хавсралт



ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД  
ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТИЙН АГУУЛГА /ХУВИАР/


Нийт: 585 өргөдөл, гомдол, санал, хүсэлтээс

1. Гомдол - 254 (43.5%)
2. Хүсэлт – 193 (32.9%)
3. Өргөдөл - 138 (23.6%)

Д/д	Агуулга	УУХҮЯ	АМГТГ	ҮГА	Тоо	Хувь
1.	Хүний нөөц	95	157	26	278	47.5%
2.	Салбарын шагнал, Гавьяат цолны нэмэгдэл	33	-	-	33	5.6%
3.	Тусгай зөвшөөрөл	21	179	-	200	34.2%
4.	Сонгон шалгаруулалт	12	7	-	19	3.2%
	<b>Бусад</b>	<b>36</b>	<b>19</b>	<b>-</b>	<b>55</b>	<b>9.4%</b>
5.	Гомдол, шаардлага	5	-	-	5	0.9%
6.	Төмөр замын бүтээн байгуулалт	3	-	-	3	0.5%
7.	Шүүхийн маргаан	2	-	-	2	0.3%
8.	Тавантолгой түлш ХХК	2	-	-	2	0.3%
9.	Эрдэнэс тавантолгой ХХК	5	-	-	5	0.9%
10.	Онцгой комиссын шийдвэр, Вакцинжуулалт	5	-	-	5	0.9%
11.	Санал, хүсэлт	11	-	-	11	1.9%
12.	ЭБМЗөвлөл, ОУИТБС ажлын албанд	3	-	-	3	0.5%
13.	Уулын ажлын төлөвлөгөө, тайлан	-	6	-	6	1.0%
14.	Газрын тосны бүтээгдэхүүний чанар, хангамж	-	13	-	13	2.2%
	<b>Нийт өргөдөл, гомдлын тоо/хувь</b>	<b>197</b>	<b>362</b>	<b>26</b>	<b>585</b>	<b>100.0%</b>

Хүснэгт 2: Зонхилж байгаа асуудлын тоо/нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь

2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн  
03/6.5 дугаар албан бичгийн 7-р хавсралт



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ,  
АГЕНТЛАГИЙН ДАРГА, АЛБАН ХААГЧ НАРТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Сайдын шуурхай хуралдааны тэмдэглэлд:

2021 оны жилийн эцсийн байдлаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон харьяа байгууллага Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн албанд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Г.Батбаяр танилцуулав.

Үүнтэй холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд дараах арга хэмжээ авч ажиллахыг яам, агентлагийн удирдлага, албан хаагчдад үүрэг болгов. Үүнд:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газарт 2021 онд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Одхүү/-т,
2. Өргөдөл, гомдлын тайлан мэдээг тогтоосон хугацаанд нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байхыг төрийн захиргааны удирдлагын газар/Г.Батбаяр/-т,
3. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэх, шийдвэрлэлтийн хуулийн хугацаа хэтрүүлсэн холбогдох албан хаагчдад хариуцлага тооцохыг яам, агентлагийн удирдлагуудад;
4. Өргөдөл нь тус яамны эрхлэх асуудлын хүрээнд шууд шийдвэрлэх боломжгүй, холбогдох газрын шийдвэр, хариуг хүлээх зэргээс шалтгаалж байгаа тохиолдолд шийдвэрлэлтийн явцыг тэмдэглэх эсхүл иргэн, аж ахуйн нэгжид өргөдлийн шийдвэрлэлтийн явцын талаарх мэдээллийг утсаар болон цахимаар тухай бүр мэдээлэхийг яам, агентлагийн удирдлагуудад.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ